



МОНГОЛ УЛС  
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А/673

Хэрлэн сум

Гадаа талбайд тусгай  
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрлэн сумын дор дурдсан аж ахуй нэгжүүд Чингисийн талбайд 2022 оны 12 дугаар сарын 28-ны 20:00-24:00 цагийг дуустал согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгосугай.

1. Хэрлэн сум "Их хаан сүлд" ХХК
2. Хэрлэн сум "Сэкрэт рэсип фүүдс" ХХК

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэхэд хяналт тавих аймгийн Комиссын дарга (Л.Батсайхан), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Д.Батхүү), Хэрлэн сумын Засаг дарга (М.Шүрэнцэцэг) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ